



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах зарим
арга хэмжээний тухай

“Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4, 8.5, 21.4, 34.3, 48.1, 49 дүгээр зүйлийн холбогдох заалтыг зөрчин худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг вэб хуудсанд байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлээгүй, Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалаар баталсан тендерийн жишиг баримт бичгийг баримтлаагүй, бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоогүй, худалдан авах ажиллагааны аргыг хэрэглээгүй зэрэг нийт 100.8 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Минжинхүүд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах;

2.2. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.3. Байгууллагад хөтлөгдөж буй албан баримт бичиг, гэрээ хэлцэл, холбогдох бусад эрх зүйн актыг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, журам, зааврын дагуу боловсруулан бүрдүүлж, хадгалах;

2.4. Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг чанд мөрдөж ажиллах;

2.5. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б. ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц. ТҮВШИНЗАЯА

0000115

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 19 ны өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт



“Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат
компанид хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Үнийн дүн /сая.төг/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Харьцуулалтын арга ашиглаагүй худалдан авсан бараа, ажил үйлчилгээ	Захирал, Санхүү, эдийн засгийн газрын дарга, холбогдох ажиллагсад	64.3	Худалдан авах ажиллагааг тооцоо судалгаатай төлөвлөж, зохион байгуулах
2	Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоогүй	Захирал, Санхүү, эдийн засгийн газрын дарга, холбогдох ажиллагсад	36.5	
Зөрчил, дутагдлын нийт дүн			100.8	